

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны  
12 дугаар сарын 27-ны өдрийн 11:00  
дугаар тушаалын хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан  
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

11:00

#### Байгууллагын нэр:

Мөрдөн байцаах алба

#### Нэгжийн нэр:

Захиргааны удирдлагын хэлтэс

#### Албан тушаалын нэр:

Орчуулагч мөрдөгч

#### Албан тушаалын ангилал, зэрэглэл:

TT-5

#### Ажлын цаг:

8 цаг

#### Ажлын байрны албан ёсны байршил:

Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,  
Самбуугийн гудамж-18

#### Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

#### Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд уртасгасан цагаар болон өндөржүүлсэн бэлэн байдал ажиллах.

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

#### Албан тушаалын зорилго:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гадаад хэлнээс Монгол хэлэнд, Монгол хэлнээс гадаад хэлэнд орчуулгыг мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэх, Интерпол болон Олон улсын эрх зүйн харилцан туслалцааны гэрээний дагуу ирүүлсэн олон улсын мөрдөгчийн даалгаврыг гэрээнд заасны дагуу хийж гүйцэтгэх.

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд орчуулагчийн үүргээр оролцож, орчуулгыг аман болон бичгийн хэлбэрээр мэргэжлийн түвшинд хийх.
2. Интерпол болон Олон улсын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу ирүүлсэн болон олон улсад хийгдэх мөрдөгчийн даалгаврын орчуулгыг хийж гүйцэтгэх.
3. Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах –Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1. Гадаад хэлнээс монгол хэлэнд, монгол хэлнээс гадаад хэлэнд мэргэжлийн өндөр түвшинд аман болон бичгийн орчуулга хийх; 1.2. Удирдлагын шийдвэрээр шаардлагатай материалыг орчуулах; 1.3. Албаны нууцад тавигдах шаардлагыг хангаж ажиллах;	Мөрдөн шалгах ажиллагааны тасралтгүй явагдах зарчим хэрэгжинэ.	Г Г Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1. Интерполын Үндэсний Төв Товчоо, Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу ирүүлсэн мөрдөгчийн даалгаврыг гэрээнд заасны дагуу хийж гүйцэтгэх; 2.2. Гадаадын иргэд, байгууллагатай холбоотой хэрэгт мөрдөгчтэй хамтарч ажиллах; 2.3. Хэлтсийн даргын баталсан хуваарь, үүргийн дагуу даалгасан ажлыг зохион байгуулж, дүнг танилцуулах.	Хамтын ажиллагаа болон Олон Улсын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу хүлээсэн үүрэг хэрэгжинэ	Г Г Г
3 дугаар зорилтын хүрээнд	4.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх; 4.2. Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн, "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх; 4.3. Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.	-	Г Г Г

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	-Хэл эзэмшихүй /0231/, -Эрх зүй /0421/, - Иргэн, өмч хамгаалал /1032/		
Мэргэшил	Англи, Орос, Хятад аль нэг хэлний "Ахисан дунд" түвшний мэдлэгтэй байх.		
Туршлага	Цагдаагийн байгууллагад З-аас доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;	

		-Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй.
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; -Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах.
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
	Бусад	-Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх. -Компьютерийн Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point программуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх. -Нууц хадгалах.

#### IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалтыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьялан  
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

Шууд харилцах байгууллага:

-Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан;

Шууд бус харилцах байгууллага:

-Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.

#### V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг  
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг  
хянаж, батлах зөвшөөрөл олгосон  
байгууллагын шийдвэр:

Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

Байгууллагын нэр: .....

Шийдвэрийн огноо: .....

Дугаар: .....

Т.ГАНЗОРИГ

2023 оны 12 дугаар сарын 21-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 21-ны өдөр

Дугаар: 8/101

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.СҮХБОЛД

2023 оны 12 дугаар сарын 21-ны өдөр

**ТАНИЛЦСАН:**

Албан тушаалтан: .....

.....

.....

20...оны .... дугаар сарын ....-ны өдөр